

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-6
<hr/>	
1. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	3-6

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 07-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 56 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ;

Тасалсан: Ж.Эрдэнэбат.

Нэг. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нар хариулж, тайлбар хийв.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд төслийн талаар танилцуулав.

Н.Энхболд: “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Хуралдаан 16 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон
“Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 56 минут.

**БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хороог нэг асуудал яаралтай хэлэлцэхээр болоод Их Хурлын Тамгын газар, Их Хурлын даргын зүгээс энэ асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцээд шийдээд өгөх нь зөв байх гэсэн асуудал гарсан учраас хуралдах гэж байна.

Ирц бүрдсэн байна. Ингээд хуралдааныг эхэлье.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бичиг ирсэн. Засгийн газар дээрээ ярьсан, Ерөнхий сайдтайгаа зөвшилцсөн. Нямбаатар аа, Засгийн газар дээрээ ярьсан, Ерөнхий сайдтайгаа зөвшилцсөн асуудал гэж ойлгож байгаа. Үүний тогтоол гаргаж өгөөч ээ гэсэн хүсэлт ирсэн байгаа.

Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай гээд ингээд Их Хурлын тухай хуулийн юу, Нямбаатар асуудлаа танилцуулчих. Асуудал нь бол энэ Хууль зүйн үндэсний хүрээлэнг Улсын Их Хурлын мэдэлд шилжүүлсэнтэй холбоотой ийм асуудал байгаа. Тэгээд үүсээд байгаа нөхцөл байдал ингэх шаардлага яагаад заавал Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэх ёстой гэсэн энэ 3 юмныхаа үндэслэлийг та танилцуулаадах, ерөөсөө.

Нямбаатар сайдад үг өгье.

Х.Нямбаатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдэд

би товчхон мэдээлэл хийе. Монгол Улсын Их Хурлын тогтоол гарсан. Уг тогтоолын үндсэн агуулга нь Хууль зүйн үндэсний хүрээлэнг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэд нэгтгэх тухай ийм агуулга бүхий тогтоол гарсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хууль тогтоомжийн хуулиар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, мөн Засгийн газрын тухай хуулиар хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, судалгааны ажил зохион байгуулах үндсэн чиг үүргийг мөн Засгийн газрын тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн чиг үүрэгт хамаатуулсан байгаа.

Дээр нь бид нар АНУ-тай байгуулсан Ил тодын хэлэлцээрээр бид хууль тогтоомж, хувийн бизнесийн эрх зүйн хууль тогтоомжуудыг ил тод болгох чиг үүрэгээ Хууль зүйн үндэсний хүрээлэнд харьяалуулсан. Дээр нь хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн сан легал инфо мэдээллийн санг эрхлэн хөтлөх чиг үүрэг Хууль зүйн үндэсний хүрээлэнд харьяалагддаг.

Ингээд дурдвал маш олон хууль тогтоомжуудаар Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Засгийн газрын бүтцийн байгууллага болж таарч байгаа юм. Гэтэл Улсын Их Хурлаас батлагдсан тогтоол нь эдгээр хууль тогтоомжуудтай зөрчилдөөд энэ Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаасаа хойш бараг 2 сар гаруй хугацаанд уг Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн учраас бид Улсын Их Хурлын даргын нэр дээр миний бие албан бичиг хүргүүлсэн. Албан бичгийн утга агуулга бол Хууль зүйн үндэсний хүрээлэнг Улсын Их Хурлын Тамгын газартай нэгтгэн зохион байгуулах нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудтай зөрчилдөх ийм нөхцөл байдал үүсээд байна. Ийм учраас цаад анх гарсан тогтоолын үндсэн агуулга бол Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаас

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хойш батлагдсаны дараах шинээр бүрэлдэн байгуулах Улсын Их Хурал бол 126 гишүүнтэй, бүтцийн хувьд олон гишүүнтэй болж байгаа учраас өнөөгийн Төрийн ордны яг өнөөгийн бүтэц орон тоогоороо ажиллахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа. Тийм учраас Хууль зүйн Үндэсний Хүрээлэн рүү Их Хурлын Тамгын газрын судалгааны алба болон бусад холбогдох байгууллагуудыг шилжүүлэх ийм бас гарцаагүй нөхцөл байдал байгаа зэргийг харгалзан үзэж ойлгож, бид бүтцийн хувьд Засгийн газрын бүтэц батлах тогтоолоор батлагдсан 45 орон тоотойгоо, чиг үүрэгтэйгээ Хууль зүйн үндэсний хүрээлэн өөр байр луу шилжин орёе.

Харин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд бид уг одоогийн Хууль зүйн үндэсний хүрээлэнг байрлаж байгаа байрыг Улсын Их Хурлын Тамгын газрын мэдэлд үлдээе гэсэн ийм агуулга бүхий албан бичгийг хүргүүлсэн. Өчигдөр миний бие Монгол Улсын Ерөнхий сайдад бас энэ үүсээд байгаа нөхцөл байдлын талаар танилцуулсан. Ерөнхий сайд бол хууль тогтоомжид нийцүүлж холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Дараагийн нэг үүсээд байгаа нөхцөл байдал нь улсын төсвийн тодотгол дагуулаад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн цалингийн санг Улсын Их Хурлын Тамгын газрын цалингийн сан руу шилжүүлчихсэн байдаг. Өнөөдөр бас Төрийн сан хаагдах өдөр болоод байгаа. Энэ 45 албан хаагч өнөөдрийн байдлаар 7 дугаар сарын цалин, хөлс түүнтэй адилтгах урамшууллаа аваагүй байгаа. Тэгэхээр өнөөдрийн Их Хурлын тогтоол гараад бид нар бас Сангийн яамныхантай Тамгын газрынхан ярилцсаны эцэст ийм байдлаар томъёолоод бүтцээрээ Хууль зүйн үндэсний хүрээлэн Засгийн газартаа, тэр дундаа Хууль зүй, дотоод хэргийн яамныхаа харьяандаа үлдээд, чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэсэн ийм агуулгаар өнөөдөр уг асуудал тогтоолын

төсөл болж орж ирж байгаа гэдгийг хэлье.

Н.Энхболд: Асуулт асуугаадах уу?

Тийм. Энэ түрүүчийн гарсан тогтоол чинь ийм л утгатай юм байна шүү дээ. 05 сарын 04-ний өдрийнх чинь. Чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэн, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнг нэгтгэж зохион байгуулж гэсэн үг чинь хүнтэй нь ч, барилгатай нь ч нэг дор болго л гэсэн ойлголт мөн биз дээ? Ер нь бол уг нь, тийм. Тэгээд одоо болохоор бид нар түрүүчийнхээ шийдвэрийг хүчингүй болгоод зөвхөн барилгыг нь аваад, хүн нь болбол яамныхаа мэдэлд үлдэх ийм юм хийж байгаа юм байна. Их Хурал түрүүчийн гаргасан тэр шийдвэрээ хүчингүй болгох гэж байгаа юм байна гэж ойлгож байна. Яах вэ байж болох л юм.

2 дугаарт, яагаад энэ Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэх ёстой юм бэ гэдгийг бас би нэг асуусан даа, тийм ээ. Энэ чинь түрүүн ярихдаа Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцсэн, бөөн асуудал болоод байсан мөн биз дээ, тийм ээ Энхбаяр тэнд нэг юм болгоод л, ингэх ёсгүй, тэгэх ёсгүй гээд л. Ингээд л баахан юм болоод л байсан. Тэгж байгаад ийм тогтоол гарсан. Тэгэхээр яагаад өнөөдөр харин Төрийн байгуулалтын байнгын хороо шийдэх болчхов гэдэг нь л сонин байна л даа. Түүн дээр Нямбаатар сайд хэлэх юм байна уу?

Занданшатар дарга.

Г.Занданшатар: Энэ Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн санал санаачилгыг судлан үзээд, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулж парламентын чадавхыг сайжруулах, парламентын төлөөллийн чадавхыг нэмэгдүүлж, гишүүдийн тоог нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор парламентын судалгаа, хууль тогтоомжийн төсөл, дүн шинжилгээ хийх, хууль зүйн судалгаа хийх чадавхыг сайжруулах, Парламентын судалгааны

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

албыг өргөтгөн зохион байгуулах ийм зайлиггүй шаардлага гарч, 06 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 44 дүгээр тогтоолын 3 дахь заалтад энэ парламентын чадавхыг сайжруулах мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэх, Улсын Их Хурлын тухай хуулийг шинэчлэх, холбогдох судалгаанууд хийх, судалгаа, дүн шинжилгээний чадавхыг сайжруулах ийм асуудлуудыг энэ 23 оны 06 дугаар сарын 15-ны өдөр болсон 44 дүгээр тогтоолд заасан учраас энэ Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөө хэрэгжүүлэх хүрээнд үүнийг ингээд Төрийн байгуулалтын байнгын хороогоор шийдээд явах нь зүйтэй юм байна. Хууль зүйн байнгын тэр тухайн Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тухай тогтоолоо тэр хүчингүй болгочихъё.

2 дахь асуудал нь бол яагаад Төрийн байгуулалтын байнгын хороо шийдэж байгаа нь тэгэхээр энэ бас парламентын чадавх, судалгааны институцийг бэхжүүлэх бол парламентын төрийн байгуулалтын харьяалах асуудалд хамаарах юм байна. Урдах тогтоолыг бол Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол бол хууль зүйн зөрчилтэй байгаад байгаа учраас Хууль тогтоомжийнхоо тухай хуультай. Ер нь цаашидаа Хууль тогтоомжийн тухай хууль энэ намрын чуулганаар хууль тогтоомжуудыг шинэчлэх шаардлага, нийцүүлэх шаардлагууд бол гарна. Тэр үед бол энэ хуулиудтай холбоотой асуудлыг хэлэлцэх байх.

Ер нь бол энэ тогтоол маань ийм бас хууль зүйн зөрчилтэй болчихоод байгаа юм. Хууль тогтоомжийн тухай хуультайгаа ч тэр, Засгийн газрын хуультай ч тэр. Тэгэхээр хуулиа хэрэгжүүлбэ, үндсэн санаагаа хэрэгжүүлбэ. Ийм хувилбар сонгоод гаргаад ирж байгаа нь бол парламентын

судалгааны хүрээлэнгээ ч бэхжүүлээд энэ Хууль зүйн үндэсний хүрээлэнтэйгээ хамтран ажиллаад, ажлын уялдаа холбоо чиг үүргийн давхардлыг арилгаад, харилцаа холбоотой хамтарч ажиллаж болно. Энэ бол цэвэр журам заавраараа шийдэгдчих бололцоотой асуудал.

2 дугаар заалтын хувьд нь бол энэ төсөв нь манай дээр ирчихсэн. Зохион байгуулалтын хувьд Засгийн газрын хуулийнхаа дагуу хууль зүй, дотоод хэргийн яам дээр байгаа учраас ийм хэлбэрээр санхүүжүүлээд явъя. Ингээд намрын чуулганаар бол бусад хууль, эрх зүйн зөрчил, төсөвт оруулах өөрчлөлт энэ тэрийг бол шийдээд ирэх оны төсөвтөө шийдээд явчихъя гэсэн ийм агуулгаар бол энэ санал санаачилгыг дэмжиж байгаа юм.

Ер нь бид нар чинь ингээд Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн институт бүгдээрээ нэг дор байрладаг. Тэгээд ер нь эхнээсээ ч энэ барилга бол анх байгуулагдахтай доогуураа холбоостой Их Хурлын харьяанд гэж газрыг нь авч байшин барилгын ажлыг нь эхлүүлж байсан ийм түүхтэй юм билээ.

Тэгээд л үүнтэй нь нийцүүлээд л ийм асуудлыг Засгийн газар Ерөнхий сайд ч дэмжээд, Хууль зүй, дотоод хэргийн яам ч гэсэн ийм чиглэлийг нь хэрэгжүүлбэ гээд ингээд шийдэж байгаа юм.

Н.Энхболд: Ийм тогтоолын төсөл байна. Энэ үү.

Тогтоох нь гээд.

1. Хууль тогтоомжийн төсөл, дүн шинжилгээ, хууль зүйн судалгаа хийх чадавхыг сайжруулах, парламентын судалгааны албыг өргөтгөн зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 23 оны 06 сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 3 дахь заалтад заасан арга хэмжээний

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн барилгыг Их Улсын Их Хурлын Тамгын газарт шилжүүлэх арга хэмжээг 23 оны 08 сарын 01-ний дотор авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой 23 оны 07-12 дугаар сарын зардлыг өмнөх түвшинд тооцож, Монгол Улсын Их Хурлын даргын 23 оны батлагдсан төсвийн багцаас гарган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар, холбогдох төсвийн захирагч нарт даалгасугай гэсэн.

Энэ тогтоол баталсантай холбогдуулаад Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 23 оны 05 сарын 04-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм төсөл танилцуулж байна.

Саяын төслийг ингээж танилцууллаа.

Дэмжье гэж байгаа санал хураалт явуулъя.

Санал хураалт яачхав.

Нямбаатар чинь манай Байнгын хороо мөн билүү, биш билүү? Мөн үү.

Нямбаатар аа, санал, дүгнэлтээ чи өөрөө уншаарай.

Би эргэлзэж байгаа учраас санал өгсөнгүй шүү, сая.

Тэгэхдээ хурлыг чинь хуралдуулж өгөөд, асуудлыг чинь шийдлээ шүү.

13.12